

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-9
<hr/>	
1. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал	4-9
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
3 дугаар сарын 30-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл-3**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Г.Уянгахишиг;

Чөлөөтэй: Б.Баярбаатар, Ц.Даваасүрэн;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Н.Учрал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Л.Дашдэмбэрэл, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр танилцуулав.

Нэр дэвшигч болон саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 1

Бүгд: 24

95.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 22 минут үргэлжилж, 32 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

*2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 05 минут.*

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 3 дахь хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Энхбатын Болормаа, Амгаланбаатарын Ганбаатар, Лувсаннямын Гантөмөр, Тогмидын Доржханд, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Нямтайширын Номтойбаяр, Эрдэнэбилэгийн Одбаяр, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Ням-Осорын Учрал, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.” Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24.1-д “Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулснаас хойш Төрийн байгуулалтын байнгын хороо ажлын 3 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана.” гэж, 24.2-т “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.” гэж тус тус заасан.

Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр танилцуулна. Үйлстөгөлдөр даргын микрофон. Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг өгье.

А.Үйлстөгөлдөр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд олонх суудал авсан Монгол Ардын намаас Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх саналыг 2026 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид ирүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулна.” гэж заасны дагуу Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг танилцуулж байна.

Ням-Осорын Учрал нь 1986 онд төрсөн. Эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 2003 онд Их Засаг лицей сургууль, 2007 онд Их Засаг их сургуулийг эрхзүйч мэргэжлээр, 2010 онд Их Британийн Лимкоквин Технологийн их сургуулийн Лондон хотын салбар, Их Британийн Бакинхам их сургуульд бизнесийн удирдлага, Олон улсын менежментийн магистр, 2013 онд ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Түвд, Будда судлалын институтэд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй.

Ням-Осорын Учрал нь 2010-2016 онд Рояал Академи, Рояал олон улсын дээд сургуулийн Ерөнхий захирал, 2012-2014 онд Нийслэлийн Монгол Ардын Намын хорооны Улс төрийн хэлтсийн дарга, 2012-2016 онд БЗД-ийн ИТХ-ын төлөөлөгч, 2015 онд Монгол Улсын Шадар сайдын зөвлөх, 2016 онд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн зөвлөх, 2016 оноос өнөөг хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-2022 онд Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, 2022-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, 2024-2025 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, 2025 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, 2025-2026 онд Монгол Улсын Их Хурлын дарга, 2025 оны 11 дүгээр сараас МАН-ын даргаар ажиллаж байна.

Ням-Осорын Учрал нь 2010 оноос хойш сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, улс төрийн болон төрийн хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглалын түвшинд ажилласан төрийн албаны туршлагатай, мэдлэгтэй бөгөөд төрийн удирдах албан тушаалд ажиллах бүрэн боломжтой хэмээн үзэж, Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулахаар санал болгож байна.

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Монгол Улсын Ерөнхий сайдаар Ням-Осорын Учралыг томилуулахтай холбогдуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналтай холбогдуулан нэр дэвшигчээс асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Гантөмөр гишүүнээр тасаллаа. Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Баярлалаа. Ер нь юу яах юм байна. Сандаг-Очир дарга цаашдаа анхаарахгүй бол МАН-ын бага хурал дээрээс дэвшсэн Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч оруулж ирнэ гэдэг бол цаашдаа ер нь болохгүй юм байна шүү. Тэгэхээр Монгол Улсын Их Хуралд бол МАН-ын бүлгийн дарга Батжаргал ч юм уу оруулж ирдэг байхгүй бол яг парламентын засаглал гэдэг дээр бол энд асуудал үүсэж байна гэж ингэж харагдаж байна.

Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Учралаас хэдэн асуулт байгаа юм. 2024 оны сонгуулийн үр дүнгээр та бүхэн бол ингээд ээлжлээд дарга хийж байгаа юм. 2024 оны сонгуульд дэвшүүлсэн амлалтуудаа яг одоо Ерөнхий сайд болохынхоо өмнө бид нарт дахиад нэг хэлээд өгмөөр байна. Та нар яг юу амласан бэ. Энэ амлалтыг мартаад янз бүрийн зүйл рүү ингээд үсчээд явахаар Монголын төр маш муухай харагдаад байгаа юм. Тогтворгүй харагдаад байгаа юм. 2024 онд амласан амлалт, тэр амлалт дээр бий болсон ялалтыг яг тэр амлалтыг хэрэгжүүлж гүйцэтгэх ийм учиртай. Би өнөөдөр албаар танай намын амлалтыг ингээд хэвлээд ирсэн. Зулпхар энэ тэр одоо энийг боловсруулахад маш их оролцсон. Өнөөдөр бүгдээрээ энийг мартчихсан байгаа юм. 1 дүгээрт энийг бид нарт маш тодорхой Их Хурлынхандаа өнөөдрийнхөө үгэн дээр хэлэх хэрэгтэй. Бид 2024 онд ингэж сонгуульд орсон. Ийм зүйл амласан. Ингэж ажил хэрэг болгож байгаа. Ингэж 2028 онд хүлээлгэж өгнө гэдгээ 1 дүгээрт хэлэх хэрэгтэй. 1 ийм асуулт байна.

2 дахь нь ер нь энэ өнгөрсөн 10 сарын хугацааг хараад байхад бол олигтой юм юу ч хийхгүй байна. Үнэндээ. Тэгэхээр Учрал дарга тэр 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад та бид 2 бол нэлээн олон өдрийг зарцуулсан. Маш олон цаг ярьсан. Яг тэр хөтөлбөрийг ажил хэрэг болгох сэтгэл зүрх танд байна уу. Би одоо мега төслүүдийг голчлоод асуумаар байгаа юм. Нөгөө Эгийн гол хаачсан бэ. Нөгөө зүүн талын босоо төмөр зам маань хаачсан бэ. Сүхбаатар аймаг руу явдаг хөндлөн төмөр зам хаачсан бэ ... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гантөмөр даргын асуусан асуултад хариулахын өмнө бас тайлбар хэлье. Ерөнхий сайдыг томилуулах процесс хуулийн дагуу өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Үндсэн хууль, Дэгийн тухай хуулийн дагуу явагдаж байгаа. Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 “Улсын Их Хуралд олонх суудал авсан нам эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг аль ч нам эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл, бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг, бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам эвсэл зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.” гэсэн Үндсэн хуулийн заалтын хүрээнд явагдаж байгаа гэдгийг хэлье. Гантөмөр гишүүний асуусан асуултад нэр дэвшигч Ням-Осорын Учрал. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Учрал: Гантөмөр гишүүний асуултад хариулъя. МАН-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр дээр миний хувьд 11 сарын 17-нд намын дарга болсныхоо дараа үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээг бол хиймэл оюун дээр суурилагд LLM гэдэг моделийн дагуу хийж гүйцэтгэж, дууссан. МАН-ын бүтцэд энэ мөрийн хөтөлбөрийг үнэлэх нэгжийг байгуулсан. Тэгээд бид үнэлсэн. Өмнө нь амласан амлалтаа хэзээ ч мартаж болохгүй. Тэгээд би бол тантай бас санал нэг байна. Тийм ч учраас шинээр намын даргаар сонгогдсоныхоо дараа энэ ажлыг эхлүүлсэн. Ингээд намын сая Бага хурлын 2 дугаар хуралдаан, 3 дугаар хуралдаан дээр мөрийн хөтөлбөрийн үнэлгээг нээлттэй танилцуулсан. Одоо бид намын мөрийн хөтөлбөрийг нэгдсэн дашбоард дээр олон нийтэд нээлттэй харуулах ажлыг 5 дугаар сарын 1-нд хийж хэрэгжүүлэх гэж байгаа. Тухайн үед 2024 оны сонгуулийн дараа хамтарсан Засгийн газар байгуулахад Гантөмөр сайд бид 2 манай намын болоод АН-ын мөрийн хөтөлбөрүүдээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж болзошгүй, шаардлагатай байгаа зохицуулалтуудыг, заалтуудыг, зорилтуудыг тухайлан ялгаж аваад энэ мөрийн хөтөлбөрүүдийн бараг 65 бараг 70 орчим хувь нь ер нь уялдаж байсан. Нөгөө бидний асуудал нэг учраас. Тэгэхээр тэр нөгөө асуудал нэг учраас мөрийн хөтөлбөрүүд уялдаж байсан. Ингээд онцлог зохицуулалтуудыг

нь нэгтгээд Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг та бид хамтдаа Их Хурлаар баталсан. Тэгэхээр миний өмнө тулгарч байгаа сорилт бол Их Хурлаар батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгэхээр та бид 2 бол тухайн үед энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хамтдаа боловсруулсан учраас энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр хэрвээ биелбэл аль аль намын мөрийн хөтөлбөр бол ер нь хангалттай түвшинд үнэлэгдэнэ.

Тийм ч учраас би бас Танд яг хариуцлагатай хэлэхэд бол Ерөнхий сайдаар томилогдсоныхоо дараа мөрийн хөтөлбөрийнхөө үнэлгээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үнэлгээнүүдийг сар тутам нээлттэй мэдээлээд ингээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тийм учраас цаашдаа бол мөрийн хөтөлбөр дээрээ үнэлэлт дүгнэлтүүдийг хийнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр тухайн үед мега төслүүдийг тухайлан заасан. Миний хувьд бол Тэргүүн шадар сайдаар 4 сар гаруй хугацаанд ажиллахдаа энэ мега төслүүдийг цаг үеийн нөхцөл шаардлагатай холбогдуулаад үнэлгээг хийсэн. Тэгэхдээ 1 ч мега төслийг бүрэн зогсоогоогүй. Үнэлгээ хийхдээ зарим төслүүдийг нь хойшлуулсан. Тэрнээс биш бүрэн зогсоогоогүй. Тэгэхээр энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг биелүүлэх үүрэг нь бол одоогийн Засгийн газарт ч хадгалагдаж байгаа. Тэгэхээр өнгөрсөн Засгийн газруудынхаа ололт амжилтыг нь ахиулах, алдаа оноог нь засах ийм л зорилтыг би бас агуулж ажиллана. Тэгээд таны хэлж байгаа энэ импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилготой Гангийн цогцолборыг бол би бас барьж аваад гүйцэтгэл рүү нь илүү анхааръя гэж бодож байна. Зэс хайлуулах цогцолбор бол бас хэрэгжээд явж байгаа. Алт цэвэршүүлэх үйлдвэр дээр бас нэлээн удаашралтай байгаа юм байна гэсэн би мэдээлэл авсан. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийг бол урагшлуулах ёстой. Мөн нөгөө хий хоолойд 3 улсын Төрийн тэргүүн нарын хэлэлцэж тохиролцсоны дагуу Монгол талд ямар ашигтай вэ гэдэг талаар хэлэлцээрийг хийнэ. Ингээд мега төслүүдийг би Ерөнхий сайдаар томилогдвол Улсын Их Хуралд аль төслүүдийг нь хойшлуулах, аль төслүүд нь ямар түвшинд байгаа юм. Эдийн засгаа идэвхжүүлэхэд аль аль төсөл нь өнөөдөр хэрэгцээтэй вэ гэдгийг бол танд би бас тухайлан ажлаа авсныхаа дараа мэдээлье гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Гантөмөр дарга нэмэлт 1 минут.

Л.Гантөмөр: Тэгэхээр Учрал сайдыг Ерөнхий сайд болохынхоо өмнө бид нар уг нь энэ Ардын намын ялалтын хөтөлбөрүүдийг өөрийнхөө амнаас сонсчихмоор байгаа юм л даа. Одоо та бол хэлэх хэрэгтэй л дээ. Бид бол сонгуулиар ийм зүйл амласан юм. Тэгээд тэрийгээ ингэж хийнэ гээд 1 дүгээрт.

2 дугаарт бол тэр мега төслүүдийг ямар хугацаанд юу явуулах вэ гэдгээ их тодорхой яримаар байна. Хиймээр байна. Маш их цаг алдлаа шүү дээ. Тэгээд хийхгүй бол ингээд л 4 жилийн дараа бид нар бүгдээрээ ард түмний өмнө очоод юу ч хийгээгүй. Эрчим хүч байхгүй, цахилгаан байхгүй, дулаан байхгүй, орон сууц байхгүй, зам байхгүй, эдийн засаг байхгүй. Нөгөө л нэг нүүрсний гэмт хэрэг ярьдаг бүлэг этгээд болж хувирах гээд байгаа байхгүй юу. Тийм учраас одоо яг миний асуултад их тодорхой хариултууд өгмөөр байна.

Ц.Сандаг-Очир: Нэр дэвшигч. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Учрал: Би танд тодорхой хариулт өгье. 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дундаж хэрэгжилт 2025 оны эцсийн байдлаар 33,2

хувьтай байгаа. Сая үнэлэгдсэн мөрийн хөтөлбөрийн 9 бүлгийн 114 заалт байдаг. Эдгээрээс 152 буюу 1/4 нь хэрэгжиж эхлээгүй, 225 буюу 37 орчим хувь нь хэрэгжилт нь хангалтгүй, 206 заалт буюу 34 хувь нь хэвийн хэрэгжиж байгаа. 31 заалт буюу 5 хувь нь хэрэгжилт сайтай. Мөрийн хөтөлбөрийн заалтуудын 60 орчим хувь нь хэрэгжээгүй байгаа дээр үнэлэлт, дүгнэлт хийх ёстой гэдэг үнэлгээг гаргасан. Хангалтгүй байна гэж дүгнэж байгаа. Тэгээд би үүн дээр ажилдаа шуурхайлан орж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх гээд зорьж ажиллана. Тэгээд таны хэлсэн бас мега төслүүдийг одоо шаардлагатай төслүүдийг нь урагшлуулахад хариуцлагатай бас хурдтай ажиллах болно.

Ц.Сандаг-Очир: Нэр дэвшигчээс гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо нэр дэвшигчид хандаж үг хэлж болно. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Үг хэлэх юм уу. Гантөмөр гишүүн үг хэлье.

Л.Гантөмөр: Одоо би чуулган дээр ороод асуух асуултуудаа түрүүлээд хэлчихмээр байна. Та бэлдэж ормоор байна. Ер нь 1 тонн нүүрсийг Гашуунсухайтын боомтоор гаргасны дараа оногдож байгаа ашиг нь яг хэдэн төгрөг юм бэ. Ашиг. Би сая 2, 3 компанийн нүүрсний яг 30 хувийн 1/3-ийн кокстой нүүрсийг хил гаргаад зарахад тэр компанид ирж байгаа ашгийн тоог би сая авсан. Татварын байгууллага дээрээс. Энийг одоо та ард түмэнд яг үнэнээр нь хэл. Татваруудаа хасаад ашиг нь хэдэн төгрөг вэ гэдгийг 1 дүгээрт.

2 дугаарт би чуулган дээр дахиад асууна. Энэ тоогоор худлаа тоглохоо бид нар болих хэрэгтэй. Эдийн засгийн тухайн улирлын өсөлтийг яаж боддог юм бэ. Өнгөрсөн Засгийн газар бол дандаа худлаа тоглосон. Дандаа худлаа ярьсан. Ямар сууриас авдаг юм, яаж тооцоолдог юм, яаж бодож гаргадаг юм. Сүүлдээ бүр тэрэндээ итгээд 1 сая 500 мянган Мвт эрчим хүчний тухай ярьж эхэлсэн. Одоо та нар бод доо. 1 сая 500 мянган Мвт-ын тухай ярьж байгаа юм. Аль улсын тухай яриад байгаа юм. Бид нар энд 300 Мвт-ын тухай ярьж байдаг. Ийм зүйл байгаа.

Тэгээд эцэст нь хэлэхэд энэ ашиг сонирхлын зөрчил гэдэг юмыг Засаг бүрдүүлэхдээ хүн 1 бүр дээр гаргаарай. Одоо бол төрөөс ямар нэгэн байдлаар бизнес хийдэг аав ээжтэй, ах дүүтэй, эхнэр хүүхэдтэй хүмүүсийг Засгийн газарт ойртуулж болохгүй. Одоо болих хэрэгтэй. Хэвлэлийн тендер авч л байдаг. Замын тендер авч л байдаг. Мал, махны татаас авч л байдаг. Бүр яг ашиг сонирхлын зөрчлийн 2022 онд билүү 2023 онд батлагдсан хууль дээр чинь их тодорхой заачихсан байгаа шүү Учрал сайд аа.

АТГ-аас хүн бүр дээр маш тодорхой ашиг сонирхлын зөрчлийг нь гаргуулах хэрэгтэй. Төртэй холбоотой 1 төгрөгийн наймаа байж болохгүй. Хамгийн сүүлд их айхтар юм гарч байна шүү дээ. Цагдаагийн цалингийн 7 тэрбум төгрөгийг нам руугаа өгөөд, хуваагаад идчихсэн гэдэг яриа. Би бол итгэхгүй байгаа. Энэндээ хүрэхгүйн тулд яах вэ гэвэл төрийн сайд болгон ямар нэгэн байдлаар төрийн бизнесээс хол байх хэрэгтэй шүү. Учрал сайд аа, тэгэхгүй та маргааш баахан сайдын нэр бариад ороод ирдэг. Дараа нь одоо бид нар сайд болгон дээр сонсгол хийнэ гэж бодож байгаа. Төртэй холбогдож уу, тендер авч уу, лиценз авсан байна уу. Ингэж маш тодорхой тоотой, тоогоор тоглодоггүй, сонирхлын зөрчлөөс ангид Засгийн газар байгуулахгүй болбол ажил чинь явахгүй нь ээ. Ерөөсөө урагшаа алхахгүй юм байна. Хүн болгон хувийн сонирхол ярьдаг.

Тэгээд хамгийн сүүлд ганц зүйл хэлмээр байгаа юм. Ер нь манай энэ Их Хурлын гишүүд, Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, Их Хурлын дарга 3-ын уулзалт бүх

уулзалтыг протоколтой хийдэг хуулийг батлах хэрэгтэй юм байна. Хэнтэй уулзсан, юу ярьсан, ямар зүйлийг өгүүлсэн бэ гэдгийг нэг бүрчлэн. Их Хурлын аль нэг гишүүнтэй уулзахдаа протоколтой уулздаг болох хэрэгтэй. Бид нар яг гэртээ байгаа юм шиг, зах дээр байгаа юм шиг, мал дээр байгаа юм шиг .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Саналын томъёоллыг уншъя.

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 24 гишүүнээс 23 гишүүн дэмжиж, 95.8 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын тогтоол

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдаар Ням-Осорын Учралыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

15.27 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ